**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ГСА-2022/37/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)<br><br>Чойр хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543156<br>Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Утас: 70543179<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Аудитор: С.Батцэцэг<br>Утас:70543179<br>Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 14
3. Аудитын тайлан ........ 15
3.1 Ерөнхий зүйл ........ 15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 15
3.4 Материаллаг байдал ........ 16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 18
3.8 Аудитын гол асуудал ........ 18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй ........ 19
4. Аудитын илрүүлэлт ........ 19
4.1 Залруулсан алдаа ........ 19
4.2 Төлбөрийн акт ........ 20
4.3 Албан шаардлага ........ 21
4.4 Зөвлөмж ........ 22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022.02.25 № 43

танай ____________-ны № ______________-т

ШИВЭЭГОВЬ СУМЫН "ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээговь сумын "Засаг даргын тамгын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шивээговь сумын "Засаг даргын тамгын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шивээговь сумын "Засаг даргын тамгын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 184,432.8 мянган төгрөгийн дараах алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 179,668.4 мянган төгрөгөөр их байна.

- Бараа материалын тайланд бүртгэлтэй ашиглагдахгүй бараа материал нөөцөлсөн болон зарцуулсан сэлбэг хэрэгслийн зарлагадаж 183,759.1 мянган төгрөгөөр данс бүртгэлээс хасаагүй байна.
- Хууль, тогтоомжинд заагдаагүй дотоод журмын дагуу олгосон буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшууллаас 430.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын суутгал тооцоогүй олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9 дэх заалт, УСНББОУС-12, УСНББОУС-14, ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Татварын ерөнхий

0С8020129

газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтыг зөрчсөн ба "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **240,699,513.96** | **286,848,260.47** |
| **2** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **2,321,923.81** | **762,523.81** |
| 3 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 2,321,923.81 | 762,523.81 |
| 4 | Төгрөг | 2,321,923.81 | 762,523.81 |
| 5 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 2,321,923.81 | 762,523.81 |
| **6** | **АВЛАГА** | **5,732,674.49** | **31,859,647** |
| 7 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 111,594.49 | |
| 8 | Бусад авлага | 5,621,080 | 31,859,647 |
| 9 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,621,080 | 31,859,647 |
| **10** | **БАРАА МАТЕРИАЛ** | **225,661,695.66** | **247,242,869.66** |
| 11 | Бэлэн бүтээгдэхүүн | 300,600 | 300,600 |
| 12 | Хангамжийн материал | 207,361,095.66 | 228,942,269.66 |
| 13 | Бичиг хэргийн материал | 2,088,015 | 2,621,289 |
| 14 | Аж ахуйн материал | 26,810,706.66 | 33,042,626.66 |
| 15 | Сэлбэг хэрэгсэл | 11,198,600 | 19,008,600 |
| 16 | Барилгын засварын материал | 164,750,524 | 164,750,524 |
| 17 | Хүнсний материал | 504,000 | |
| 18 | Бусад хангамжийн материал | 2,009,250 | 9,519,230 |
| 19 | Мал амьтад | 18,000,000 | 18,000,000 |
| **20** | **НӨӨЦИЙН БАРАА** | **6,983,220** | **6,983,220** |
| 21 | Бусад нөөц | 6,983,220 | 6,983,220 |
| **22** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,354,531,575.94** | **1,123,211,950.13** |
| **23** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,354,531,575.94** | **1,123,211,950.13** |
| 24 | Биет хөрөнгө | 1,339,473,992.35 | 1,107,803,116.77 |
| 25 | Барилга, байгууламж, орон сууц | 1,049,883,096.13 | 1,049,883,096.13 |
| 26 | Хуримтлагдсан элэгдэл | -349,101,888.7 | -435,515,805.1 |
| 27 | Авто-тээврийн хэрэгсэл | 221,145,250 | 221,145,250 |
| 28 | Хуримтлагдсан элэгдэл | -98,323,291.91 | -126,597,458.46 |
| 29 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 63,881,683 | 74,402,683 |
| 30 | Хуримтлагдсан элэгдэл | -16,375,874.19 | -30,705,445.21 |
| 31 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,589,598.5 | 40,769,598.5 |
| 32 | Хуримтлагдсан элэгдэл | -2,993,432.12 | -8,400,972.29 |
| 33 | Зам, гүүрийн байгууламж | | 406,835,211 |
| 34 | Хуримтлагдсан элэгдэл | | -258,057,543.72 |
| 35 | Бусад үндсэн хөрөнгө | 834,850,607.99 | 428,015,396.99 |
| 36 | Хуримтлагдсан элэгдэл | -397,081,756.35 | -253,970,894.07 |
| 37 | Биет бус хөрөнгө | 15,057,583.59 | 15,408,833.36 |
| 38 | Програм хангамж | 4,070,050 | 4,870,050 |
| 39 | Хуримтлагдсан элэгдэл | -3,450,466.41 | -3,899,216.64 |
| 40 | Бусад биет бус хөрөнгө | 14,438,000 | 14,438,000 |
| **41** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,595,231,089.9** | **1,410,060,210.6** |
| **42** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **76,250.04** | **635,544.2** |
| **43** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **76,250.04** | **635,544.2** |
| 44 | Өглөг | 76,250.04 | 635,544.2 |
| 45 | Ажилчидтай холбогдсон өглөг | 76,250.04 | 635,544.2 |
| **46** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,595,154,839.86** | **1,409,424,666.4** |
| 47 | Засгийн газрын хувь оролцоо | 1,595,154,839.86 | 1,409,424,666.4 |

| | | | |
|---|---|---|---|
| 48 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 639,608,941.55 | 639,608,941.55 |
| 49 | Хуримтлагдсан үр дүн | 188,087,096.03 | 2,356,922.57 |
| 50 | Өмнөх үеийн үр дүн | -208,036,666.11 | 188,764,191.79 |
| 51 | Тайлант үеийн үр дүн | 396,123,762.14 | -186,407,269.22 |
| 52 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 767,458,802.28 | 767,458,802.28 |
| **53** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,595,231,089.9** | **1,410,060,210.6** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,036,174,513.01** | **519,219,680** |
| **2** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **567,649,942.36** | **25,285,180** |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 567,649,942.36 | 25,285,180 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,615,923.81 | 744,600 |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,615,923.81 | 744,600 |
| 6 | Бусад орлого | 6,211,408 | |
| 7 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 411,227,303.05 | 23,410,980 |
| 8 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 145,595,307.5 | 1,129,600 |
| **9** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **468,524,570.65** | **493,934,500** |
| 10 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 34,099,873 | 15,217,000 |
| 11 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 5,000,000 |
| 12 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,189,000 | 7,172,000 |
| 13 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,910,873 | 3,045,000 |
| 14 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 434,424,697.65 | 478,717,500 |
| 15 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 434,424,697.65 | 478,717,500 |
| **16** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **635,248,946.94** | **705,626,949.22** |
| **17** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **635,248,946.94** | **705,626,949.22** |
| **18** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **611,262,516.29** | **681,389,877.91** |
| 19 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 236,586,281.69 | 240,540,880.86 |
| 20 | Үндсэн цалин | 236,461,860.69 | 240,540,880.86 |
| 21 | Нэмэгдэл | 124,421 | |
| 22 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,383,529.31 | 31,742,033.29 |
| 23 | Тэтгэврийн даатгал | 20,990,798.16 | 22,659,097.88 |
| 24 | Тэтгэмжийн даатгал | 2,925,351.02 | 2,445,744.97 |
| 25 | ҮОМШӨ-ний даатгал | 1,859,820.02 | 1,916,275.97 |
| 26 | Ажилгүйдлийн даатгал | 546,141.83 | 429,174.04 |
| 27 | Эрүүл мэндийн даатгал | 4,061,418.28 | 4,291,740.43 |
| 28 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 89,648,368.46 | 86,750,384.85 |
| 29 | Гэрэл, цахилгаан | 14,015,938.46 | 14,915,946.85 |
| 30 | Түлш, халаалт | 53,328,660 | 55,000,140 |
| 31 | Цэвэр, бохир ус | 22,303,770 | 16,834,298 |
| 32 | Хангамж, бараа материалын зардал | 37,599,159 | 46,002,665.1 |
| 33 | Бичиг хэрэг | 4,636,845 | 5,299,290 |
| 34 | Тээвэр, шатахуун | 18,470,000 | 24,833,660 |
| 35 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,120,724 | 3,578,711.1 |
| 36 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000 | 120,000 |
| 37 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 20,000 |
| 38 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 10,251,590 | 12,151,004 |
| 39 | Нормативт зардал | 542,521.5 | 7,791,263 |
| 40 | Хоол, хүнс | 542,521.5 | 7,791,263 |
| 41 | Томилолт, зочны зардал | 4,454,000 | 4,607,000 |
| 42 | Дотоод албан томилолт | 4,454,000 | 4,607,000 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,875,299 | 3,171,025 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,485,124 | 801,550 |
| 45 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000 | |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 1,647,175 | 988,875 |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 219,000 | 808,100 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000 | 132,500 |
| 49 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000 | 440,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 50 | Газрын төлбөр | 132,000 | |
| 51 | Бараа үйлчилгээний бусад зардал | 189,173,357.33 | 260,784,625.81 |
| 52 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,229,250 | 10,964,000 |
| 53 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 187,944,107.33 | 249,820,625.81 |
| **54** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,986,430.65** | **24,237,071.31** |
| 55 | Бусад урсгал шилжүүлэг | 13,724,146.48 | 14,216,968 |
| 56 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 7,817,000 |
| 57 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,724,146.48 | 6,399,968 |
| 60 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 10,262,284.17 | 10,020,103.31 |
| 61 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,249,811.17 | 10,020,103.31 |
| 62 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 12,473 | |
| **63** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **400,925,566.07** | **-186,407,269.22** |
| **64** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **4,801,803.93** | |
| 65 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 4,801,803.93 | |
| **66** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **396,123,762.14** | **-186,407,269.22** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 639,608,941.55 | 767,458,802.28 | -208,036,666.11 | 1,199,031,077.72 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 639,608,941.55 | 767,458,802.28 | -208,036,666.11 | 1,199,031,077.72 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | 396,123,762.14 | 396,123,762.14 |
| 4 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 639,608,941.55 | 767,458,802.28 | 188,087,096.03 | 1,595,154,839.86 |
| 5 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 639,608,941.55 | 767,458,802.28 | 188,087,096.03 | 1,595,154,839.86 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 677,095.76 | 677,095.76 |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 639,608,941.55 | 767,458,802.28 | 188,764,191.79 | 1,595,831,935.62 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | -186,407,269.22 | -186,407,269.22 |
| **9** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **639,608,941.55** | **767,458,802.28** | **2,356,922.57** | **1,409,424,666.4** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **473,140,494.46** | **494,679,100** |
| **2** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,615,923.81** | **744,600** |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 4,615,923.81 | 744,600 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,615,923.81 | 744,600 |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,615,923.81 | 744,600 |
| **6** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **468,524,570.65** | **493,934,500** |
| 7 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 34,099,873 | 15,217,000 |
| 8 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 5,000,000 |
| 9 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,189,000 | 7,172,000 |
| 10 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,910,873 | 3,045,000 |
| 11 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 434,424,697.65 | 478,717,500 |
| 12 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 434,424,697.65 | 478,717,500 |
| **13** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **461,553,370.65** | **493,638,500** |
| **14** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **461,553,370.65** | **493,638,500** |
| **15** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **437,566,940** | **442,443,997.43** |
| 16 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 223,226,066.41 | 223,316,760.97 |
| 17 | Үндсэн цалин | 160,209,303.93 | 145,747,822.23 |
| 18 | Нэмэгдэл | 45,431,433.6 | 68,709,569.09 |
| 19 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,025,525.41 | 8,859,369.65 |
| 20 | Гэрээт ажлын хөлс | 12,559,803.47 | |
| 21 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,808,300 | 29,794,200 |
| 22 | Тэтгэврийн даатгал | 19,613,178.8 | 20,941,707.6 |
| 23 | Тэтгэмжийн даатгал | 634,776.5 | 2,531,200.4 |
| 24 | ҮОМШӨ-ний даатгал | 2,183,770.94 | 1,616,000 |
| 25 | Ажилгүйдлийн даатгал | 2,508,500 | 404,000 |
| 26 | Эрүүл мэндийн даатгал | 3,868,073.76 | 4,301,292 |
| 27 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 89,648,368.46 | 86,750,384.85 |
| 28 | Гэрэл, цахилгаан | 14,015,938.46 | 14,915,946.85 |
| 29 | Түлш, халаалт | 53,328,660 | 55,000,140 |
| 30 | Цэвэр, бохир ус | 22,303,770 | 16,834,298 |
| 31 | Хангамж, бараа материалын зардал | 21,267,824 | 21,248,699.1 |
| 32 | Бичиг хэрэг | 3,736,200 | 5,832,564 |
| 33 | Тээвэр, шатахуун | 11,450,000 | 10,529,250 |
| 34 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,340,724 | 3,578,711.1 |
| 35 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000 | 120,000 |
| 36 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,620,900 | 1,188,174 |
| 37 | Нормативт зардал | 819,000 | 7,606,488 |
| 38 | Хоол, хүнс | 504,000 | 7,346,488 |
| 39 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 315,000 | 260,000 |
| 40 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,293,300 | 12,160,700 |
| 41 | Багаж, техник, хэрэгсэл | 2,104,700 | 640,700 |
| 42 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,600 | 860,000 |
| 43 | Урсгал засвар | 6,388,000 | 10,660,000 |
| 44 | Томилолт, зочны зардал | 4,454,000 | 4,607,000 |
| 45 | Дотоод албан томилолт | 4,454,000 | 4,607,000 |
| 46 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 52,220,431.13 | 4,539,475 |
| 47 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,830,256.13 | 2,170,000 |
| 48 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000 | |
| 49 | Даатгалын үйлчилгээ | 1,647,175 | 988,875 |

| | | | |
|---|---|---|---|
| 50 | Тээврийн хэрэгслийн татвар | 219,000 | 808,100 |
| 51 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000 | 132,500 |
| 52 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000 | 440,000 |
| 53 | Газрын төлбөр | 132,000 | |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,829,650 | 52,420,289.51 |
| 55 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,829,650 | 52,420,289.51 |
| **56** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,986,430.65** | **51,194,502.57** |
| 57 | Бусад урсгал шилжүүлэг | 13,724,146.48 | 41,174,399.26 |
| 58 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 7,817,000 |
| 59 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,724,146.48 | 33,357,399.26 |
| 60 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 10,262,284.17 | 10,020,103.31 |
| 61 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,249,811.17 | 6,424,652.31 |
| 62 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 12,473 | 3,595,451 |
| **63** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **11,587,123.81** | **1,040,600** |
| **64** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **9,265,200** | **2,600,000** |
| **65** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,265,200** | **2,600,000** |
| 66 | Дотоод эх үүсвэрээр | 9,265,200 | 2,600,000 |
| 67 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,265,200 | 2,600,000 |
| **68** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-9,265,200** | **-2,600,000** |
| 69 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 2,321,923.81 | -1,559,400 |
| 70 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 2,321,923.81 |
| 71 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,321,923.81 | 762,523.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **478,717,500** | **472,292,847.69** | **6,424,652.31** |
| **2** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **478,717,500** | **472,292,847.69** | **6,424,652.31** |
| **3** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **437,543,100** | **431,118,448.43** | **6,424,651.57** |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 225,000,000 | 223,316,760.97 | 1,683,239.03 |
| 5 | Үндсэн цалин | 157,566,300 | 145,747,822.23 | 11,818,477.77 |
| 6 | Нэмэгдэл | 52,154,700 | 68,709,569.09 | -16,554,869.09 |
| 7 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,279,000 | 8,859,369.65 | 6,419,630.35 |
| 8 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,375,400 | 29,794,200 | 581,200 |
| 9 | Тэтгэврийн даатгал | 21,379,400 | 20,941,707.6 | 437,692.4 |
| 10 | Тэтгэмжийн даатгал | 2,246,000 | 2,531,200.4 | -285,200.4 |
| 11 | ҮОМШӨ-ний даатгал | 1,800,000 | 1,616,000 | 184,000 |
| 12 | Ажилгүйдлийн даатгал | 450,000 | 404,000 | 46,000 |
| 13 | Эрүүл мэндийн даатгал | 4,500,000 | 4,301,292 | 198,708 |
| 14 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 89,756,000 | 86,677,323.85 | 3,078,676.15 |
| 15 | Гэрэл, цахилгаан | 14,500,000 | 14,842,885.85 | -342,885.85 |
| 16 | Түлш, халаалт | 56,256,000 | 55,000,140 | 1,255,860 |
| 17 | Цэвэр, бохир ус | 19,000,000 | 16,834,298 | 2,165,702 |
| 18 | Хангамж, бараа материалын зардал | 18,146,700 | 18,146,699.1 | 0.9 |
| 19 | Бичиг хэрэг | 4,576,700 | 5,393,064 | -816,364 |
| 20 | Тээвэр, шатахуун | 8,744,000 | 8,007,250 | 736,750 |
| 21 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,100,000 | 3,578,711.1 | 521,288.9 |
| 22 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000 | 120,000 | 20,000 |
| 23 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 586,000 | 1,047,674 | -461,674 |
| 24 | Нормативт зардал | 260,000 | 260,000 | 0 |
| 25 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 260,000 | 260,000 | 0 |
| 26 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,730,000 | 13,660,700 | 69,300 |
| 27 | Багаж, техник, хэрэгсэл | 3,310,000 | 3,240,700 | 69,300 |
| 28 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 860,000 | 860,000 | 0 |
| 29 | Урсгал засвар | 9,560,000 | 9,560,000 | 0 |
| 30 | Томилолт, зочны зардал | 4,950,000 | 4,607,000 | 343,000 |
| 31 | Дотоод албан томилолт | 4,950,000 | 4,607,000 | 343,000 |
| 32 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,791,000 | 4,539,475 | 251,525 |
| 33 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,170,000 | 2,170,000 | 0 |
| 34 | Даатгалын үйлчилгээ | 1,072,000 | 988,875 | 83,125 |
| 35 | Тээврийн хэрэгслийн татвар | 827,000 | 808,100 | 18,900 |
| 36 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 212,000 | 132,500 | 79,500 |
| 37 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000 | 440,000 | 0 |
| 38 | Газрын төлбөр | 70,000 | | 70,000 |
| 39 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,534,000 | 50,116,289.51 | 417,710.49 |
| 40 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,534,000 | 50,116,289.51 | 417,710.49 |
| 41 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,174,400 | 41,174,399.26 | 0.74 |
| 42 | Бусад урсгал шилжүүлэг | 41,174,400 | 41,174,399.26 | 0.74 |
| 43 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,817,000 | 7,817,000 | 0 |
| 44 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,357,400 | 33,357,399.26 | 0.74 |
| **45** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **478,717,500** | **472,292,847.69** | **6,424,652.31** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **46** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **478,717,500** | **472,292,847.69** | **6,424,652.31** |
| 47 | Орон нутгийн төсвөөс | 478,717,500 | 472,292,847.69 | 6,424,652.31 |
| 48 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 45 | 45 | |
| 49 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 3 | 3 | |
| 50 | Төсвийн байгууллага | 3 | 3 | |
| 51 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 21 | 21 | |
| 52 | Удирдах ажилтан | 5 | 5 | |
| 53 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 12 | |
| 54 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 | |
| 55 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 21 | 21 | |
| 56 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | |
| 57 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 | |
| 58 | Улс төрийн албан хаагч (УТ) | 4 | 4 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **15,217,000** | **-15,217,000** |
| **3** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **15,217,000** | **-15,217,000** |
| **4** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **11,621,549** | **-11,621,549** |
| **5** | **Байр ашиглалттай холбоотой тотмол зардал** | | **73,061** | **-73,061** |
| 6 | Гэрэл, цахилгаан | | 73,061 | -73,061 |
| **7** | **Хангамж, бараа материалын зардал** | | **3,102,000** | **-3,102,000** |
| 8 | Бичиг хэрэг | | 439,500 | -439,500 |
| 9 | Тээвэр, шатахуун | | 2,522,000 | -2,522,000 |
| 10 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 140,500 | -140,500 |
| **11** | **Нормативт зардал** | | **7,346,488** | **-7,346,488** |
| 12 | Хоол, хүнс | | 7,346,488 | -7,346,488 |
| **13** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **1,100,000** | **-1,100,000** |
| 14 | Урсгал засвар | | 1,100,000 | -1,100,000 |
| **15** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **3,595,451** | **-3,595,451** |
| **16** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **15,217,000** | **-15,217,000** |
| **17** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **15,217,000** | **-15,217,000** |
| 9 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | | 5000,000 | -5000,000 |
| 9 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 7,172,000 | -7,172,000 |
| 10 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсоннэмэлт орлого | | 3,045,000 | -3,045,000 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалт, бараа материал нөөцөлсөн болон зарцуулсан сэлбэг хэрэгсэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/77 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар” нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оновчтой бодлого төлөвлөлт бүтээмж шинэчлэлд тулгуурласан, иргэнээ дээдэлсэн суралцагч хамт олон байна” зорилттой үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шивээговь сумын Засаг аргын тамгын газар” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний 635,248.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,352.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 4,764.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 185,170.8 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,321.9 | 762.5 | -1,559.4 |
| Авлага | 5,732.6 | 31,859.6 | 26,127.0 |
| Бараа материал | 232,644.9 | 254,226.1 | 21,581.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,354,531.6 | 1,123,212.0 | -231,319.6 |
| **Нийт хөрөнгө** | **1,595,231.0** | **1,410,060.2** | **-185,170.8** |
| Өр төлбөр | 76.2 | 635.6 | 559.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 639,608.9 | 639,608.9 | 0 |
| Хуримтлагдсан үр дүн | 188,087.1 | 2,356.9 | -185,730.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 767,458.8 | 767,458.8 | 0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,595,231.0** | **1,410,060.2** | **-185,170.8** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 762.5 мянган төгрөг болж 1,559.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ахмадын санг зарцуулж, тайлант онд нэмж үүсгэсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 31,859.6 мянган төгрөг болж 26,238.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шүүхээр тогтоосон акт ба өмнөх оны хуримтлагдсан авлага 5,621.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 254,226.1 мянган төгрөг болж 21,581.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал болон сэлбэг хэрэгслийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,148,155.3 мянган төгрөг болж 206,376.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь тайлант хугацаанд нийт 43,511.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Шивээговь сумын ОНХС-аас 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/220 дугаар захирамжаар 40,911.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвөөс 2,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 635.6 мянган төгрөг болж 559.4 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өглөгөөс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 2,356.9 мянган төгрөг болж, 185,730.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

"Шивээговь сумын Засаг даргын тамгын газар"-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 516,954.8 мянган төгрөгөөр буюу 50.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн орлого, нэмэлтийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 70,378.0 мянган төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бараа ажил үйлчилгээ бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн залруулга нь 677.1 мянган төгрөгөөр өмнөх үеэс өссөн нь өмнөх онд Шивээговь сумын ОНХС-аас авсан хөрөнгийг тайлант онд бүртгэсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 558,027.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 558,027.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 114,523.1 мянган төгрөгөөр бууруулж 443,504.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс бууруулж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас шалтгаалсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 443,504.4 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвийн хуваарийг 4 удаагийн өөрчлөлт орсны дараа нийт 478,717.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 480,717.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 472,292.8 мянган төгрөгийг зарцуулж, 8,424.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 472,292.8 мянга буюу 98.0 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 1,683.2 мянга, НДШ зардлаас 581.2 тогтмол зардлаас 5,078.7 мянга, багаж, техник хэрэгсэл 69.3 мянга, дотоод томилолтын зардал 343.0 мянга, бусдаас гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 251.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 417.7 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 70106 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 8,424.6 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 14,972.0 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд Шивээ-Овоо ХК, Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн ОНХС, Дундговь аймгийн Онцгой байдлын газар, Шивээговь сумын ОНХС зэрэг байгууллагаас постод ажиллаж байгаа хүмүүсийн хоолны зардал 7,346.5 мянга, гэрэл цахилгааны зардал 73.1 мянга, бичиг хэргийн зардалд 439.5 мянга, тээвэр, шатахууны зардалд 2,522.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлийн зардалд 140.5 мянга, урсгал засварын зардалд 1,100.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,350.5 мянган төгрөгийг орон төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн

### 3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

"Шивээговь сумын Засаг даргын тамгын газар" нь 2021 онд нийт 478,717.5 мянган төгрөгийн 174 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан ба хөрөнгө зарцуулсан 2 тушаал, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг огт мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад хуульд нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 260,146.3 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 21,786.6 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 59.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 5,257.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | - | - | - |
| Албан шаардлага | 4 | 5,257.0 | 4 | 5,257.0 | | | |
| Төлбөрийн акт | 1 | 59.5 | 1 | 59.5 | | | |
| **Нийт дүн** | **6** | **5,316.5** | **6** | **5,316.5** | | | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 229,031.6 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчил илэрснээс, 15,437.6 мянган төгрөгийн 6 алдааг завсрын аудитаар, 12,657.8 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 673.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 16,503.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 183,759.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 28,095.4 мянган төгрөгийн залруулгаас 15,437.6 мянган төгрөгийг завсрын аудитаар, 12,657.8 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмнөх онд НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй 788.7 мянган төгрөгийг зөвлөмж өгсний дагуу залруулга хийгдсэн.
2. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 8,027.2 мянган төгрөгөөр залруулга хийгдсэн.
3. Цалингийн зардал бууруулж бичсэн 5,621.7 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
4. Санхүүгийн тайланд өмнөх оны үзүүлэлтүүдийг тайлагнаагүй зөвлөмж өгсний дагуу залруулга хийгдсэн.
5. Нярвын шатахууны тайлан болон санхүүгийн тайлангийн бараа материалын тайланг зөрүүтэй тайлагнасан 1000.0 мянган төгрөгийн залруулга завсрын аудитаар хийгдсэн.
6. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, программ хангамж, бусад биет бус хөрөнгийн нярвын тайланг гаргаагүйг улирал бүр үлдэгдэлтэй тайланг гаргах талаар завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу залруулсан.
7. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй бараа материалын шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгээгүй 7,510.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулга хийгдсэн.
8. Гэрээний заалтыг зөрчин жилийн дундуур халаалтын зардлын үйлчилгээний төлбөр нэмэгдүүлснийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 5,147.8 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад тус тус залруулсан.

**4.2 Төлбөрийн акт**

4.2.1 Томилолтын зардлыг 163.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалын заалтуудыг тус тус зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6, 4.2.3.8-д заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.2.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн Д.Отгонбаатар нь 2021 оны 4 дүгээр сараас эхлэн шинээр ажилд орсон бөгөөд байгууллагын дотоод журмын 4.2.7 дахь заалтыг зөрчин ээлжийн амралт олгохдоо цалин, ээлжийн амралтын олговрыг 80.7 мянган төгрөгөөр давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7, Монгол улсын эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 7 дах заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.2.3 Хууль, тогтоомжид тусгайлан заагдаагүй боловч дотоод журмын дагуу олгосон буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшууллаас ХХОАТ-ын 430.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

**4.3 Албан шаардлага**

4.3.1 Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 7,862.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.3.2 Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт дутуу, хаашаа явсан нь тодорхойгүй, тээврийн хэрэгслийн дугаар болон марк байхгүй зэрэг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 5,543.5 мянган төгрөгийг шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус зөрчсөн ба эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.3.3 Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгдээгүй, өмч хамгаалах зөвлөлийн тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.3.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 936.0 мянган төгрөгийн 2 тушаал, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг огт

мэдээлээгүй бөгөөд нийт 12 мэдээлэл хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.4.4, 6.4.8, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2.9, 3.2.11, 3.2.14 дэх заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Дотоод хяналттай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн ба "иж бүрэн байх, оршин байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулах

***2. Бараа материал холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Бараа материалын тайланд бүртгэлтэй 183,759.1 мянган төгрөгийн өртөг бүхий ашиглагдахгүй бараа материал нөөцөлсөн болон зарцуулсан сэлбэг хэрэгслийг тухай бүр зарлагадаж данс бүртгэлээс хасаагүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг хөрөнгийн нэрээр бус ажил нэрээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Цаашид бараа материалыг тавьж олгосон тухай бүрт нь зарлагадаж хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шивээговь сумын Засаг даргын тамгын газар | 17 | 229,031.6 | 8 | 28,095.4 | 3 | 673.7 | 4 | 16,503.4 | 2 | 183,759.1 |